



## **САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

---

### **ОРХОН АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ ШИЛЖСЭН АЖЛУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН**

БАЙГУУЛЛАГА: ОРХОН АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ХУГАЦАА: 2026.01.02-2026.04.30

**ОРХОН АЙМАГ  
2026 он**

Аудит хийгдсэн байгууллага:  
"ОРХОН АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР"

Огноо:

2026.05.22

ДОТООД АУДИТЫН НЭГЖ:  
ОРХОН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**-ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН-**

АУДИТЫН НЭР: ДОТООД АУДИТ  
ЖИЛ: 2026.01.02-2025.04.30

2026 ОН


**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:**  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**АУДИТАД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА:**  
“ОРХОН АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР”

**АУДИТЫН ТӨРӨЛ:** ТӨЛӨВЛӨГӨӨТ ДОТООД АУДИТ

**АУДИТЫН ХУГАЦАА :** 2026.01.02-2026.04.30

**ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА:**  
ГАЗРЫН ДАРГА-САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.САЙЗМАА

**АУДИТ ГҮЙЦЭТГЭСЭН:**  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ДОТООД АУДИТОР  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

A handwritten signature in black ink.

Л.БУЛГАНЦЭЦЭГ



ОРХОН АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ДОТООД АУДИТЫН  
ТАНИЛЦУУЛГА

2026 оны 05 сарын 22

Дугаар 28/26

Баян-Өндөр сум

ОРХОН АЙМГИЙН  
“ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР”  
/2026.01.02-2026.04.30/

## 1. ДОТООД АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

Сангийн сайдын 2026.04.16-ны өдрийн 01/3386 дугаартай “Худалдан авах ажиллагааны тайлан, мэдээлэл ирүүлэх тухай” албан бичиг, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан 2026.04.27-ны өдрийн 31/26 дугаартай удирдамжийн хамрах хүрээнд нийцүүлэн Орхон аймгийн “Худалдан авах ажиллагааны газар”-ын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тайланд (**2026.01.02-2026.04.30**) эхний 4 сарын байдлаар Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт “Харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна” заалт, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэгт заасан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж, түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина.” зэрэг хэсгүүдийг тус тус үндэслэн, Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Дотоод аудитын Мэргэжлийн практикийн Олон улсын стандартын дагуу Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын хэрэгжилтэд Ахлах мэргэжилтэн Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Булганцэцэг дотоод аудит хийж, тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны түвшинг тодорхойлж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго

Дотоод аудитыг Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д нийцүүлэн Төрийн сангийн дансны хуулга, баримт бичгийн бүрдэл, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалд тулгуурлан дүгнэлт өгч, аймгийн Худалдан авах ажиллагааны 2026.01.02-2026.04.30-ны өдрийн байдлаар Засаглалын удирдлага, Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг үнэлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх замаар аудитын үр өгөөжийг дээшлүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

## 2.2 Аудитын цар хүрээ

Дотоод аудитаар Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц, Сангийн сайдын 2026.04.16-ны өдрийн 01/3386 дугаартай албан бичигт заасан дараах үйл ажиллагааг хамруулсан болно.

Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байдал
2. Батлагдсан төлөвлөгөөг цахим системд хуульд заасан хугацаанд нийтэлсэн байдал
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулалт
4. Тендер шалгаруулалтын аргыг хуульд нийцүүлсэн сонгосон байдал
5. Төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалт зарласан, худалдан авах ажиллагааны системд нийтэлсэн байдал
6. Тендер шалгаруулалтын баримт бичгийг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан эсэх, түүнтэй холбоотой гомдол гаргасан байдал
7. Тендер шалгаруулалтын баримт бичгийн асуудлаар гарсан гомдол захиалагчийн талд шийдвэрлэгдсэн эсэх, үгүй бол гомдол хянан шийдвэрлэг байгууллагын шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээ авсан байдал
8. Үнэлгээний хороог хуульд заасан журмын дагуу байгуулсан байдал
9. Тендерийн үнэлгээг хууль, журамд нийцүүлсэн байдал
10. Тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчийн шийдвэр гарсан өдөр цахим системд нийтэлсэн байдал
11. Худалдан авах гэрээг хуульд заасан хугацаанд байгуулсан эсэх
12. Гэрээний баталгааг хуульд заасан хэмжээгээр авсан байдал
13. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, цахим системийн бүртгэл хөтлөлт
14. Гэрээний гүйцэтгэл хугацаандаа биелсэн байдал
15. Худалдан авах ажиллагаанд гарсан хэмнэлт
16. Гомдол маргаан шийдвэрлэлт
17. Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдол захиалагчийн талд шийдвэрлэгдсэн байдал
18. Дотоодын үйлдвэрлэлээс бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт
19. Худалдан авах ажиллагааны баримт бичгийн бүрдэл хангагдсан байдал
20. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил, эрсдэл

## 2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар аудитын зорилго, зарчмыг танилцуулж, Засаглал, эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын тогтолцооны талаар АБ-1001, АБ-1002, АБ-1003, АБ-1004 дугаартай ажлын баримтаар тус байгууллагын удирдлагаас асуулга авч, аудитын хүрээнд ирүүлсэн үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны баримт материалд дүн шинжилгээ хийж, ярилцлага, уулзалтаар баталгаажуулан дүгнэлт өгч ажиллалаа.

Аудитад дараах хууль, эрх зүйн баримтуудыг эх сурвалж болгон ашигласан. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол улсын жил бүрийн Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Авто замын тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”

- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн Сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Зам тээвэр, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм”
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалаар баталсан “Төсөв зохиох дүрэм”
- Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага

### **3. БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА:**

Монгол улсын Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоолоор 2021.12.14-ний өдрийн "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоолын 4 дэх заалтын 4.26 дахь хэсэгт “Худалдан авах ажиллагааны газар” гэж нэмэлт өөрчлөлт оруулснаар Орон нутгийн өмчийн газраас бүтэц, орон тоо салган, аймгийн Засаг даргын 2023.11.02-ны өдрийн А/845 дугаар захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, орон нутагт төрийн худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байна. Аймгийн Засаг даргын 2025.05.12-ны өдрийн Б/11 дүгээр захирамжаар удирдлагыг томилсон байна.

Тус байгууллага нь “Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хариуцлагатай, ил тод, нээлттэй зохион байгуулан тэгш, шударга өрсөлдөх таатай орчныг бүрдүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.” гэж эрхэм зорилгоо тодорхойлон дараах 3 зорилтыг дэвшүүлсэн байна.

Үүнд:

1. *Худалдан авах ажиллагааг төлөвлөн, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулж, тайлагнах*
2. *Төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, үр чадвар, чадавхыг бэхжүүлэх зарчмыг баримтлан, байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн, чадварлаг баг бүрдүүлэх*
3. *Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын зорилт, ажлын биелэлтийг хангуулж тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах*

#### **3.1. ЗАСАГЛАЛЫН УДИРДЛАГЫН ТАЛААР**

Засаглах удирдлага нь дараах эрх үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Үүнд:

1. *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах тухайн жилийн төсөл, арга хэмжээний жагсаалт, төлөвлөгөөг боловсруулах, батлуулж, нийтэд мэдээлэх*
2. *Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд шуурхай цахимаар зохион байгуулах, хяналт тавих*
3. *Худалдан авах ажиллагааг тайлагнах*
4. *Харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хяналт тавих*

### **Аймгийн Засаг дарга:**

Худалдан авах ажиллагааны эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоог бодлогоор хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагналд үндэслэн шийдвэр гаргах замаар засаглах удирдлагыг хэрэгжүүлж байна.

### **Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал:**

- *Аймгийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах*
- *Худалдан авах ажиллагаанд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулах*
- *Төсвийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт тавих*

### **Сангийн яам:**

- *Худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалт хийх, зөвлөмж өгөх*
- *Төрийн худалдан авах ажиллагааны газар:*
- *Худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих*

Худалдан авах ажиллагааны газар нь Төрийн худалдан авах ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулж, засаглалын удирдлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлж ажиллаж байгаа хэдий ч үйл ажиллагааны баримтжуулалт хийгдээгүй тул засаглалын удирдлагыг **3 дугаар түвшинд буюу ТОМЪЁОЛСОН** түвшинд байна гэж дүгнэлээ.

### **3.2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР**

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа дараах байдлаар зохион байгуулж байгаа хэдий ч байгууллагын хэмжээнд эрсдэлийг удирдах нэгдсэн бодлого, журам боловсруулаагүй, баримтжуулсан мэдээлэл байхгүй байна.

Үүнд:

1. *Байгууллагын шуурхай хурлаар эрсдэлтэй асуудлын мэдээллийг албан хаагчдад тогтмол танилцуулдаг.*
2. *Үйл ажиллагааны явцад илэрсэн эрсдэлийн мэдээллийг тухай бүр тогтоосон хугацаанд шуурхай мэдээлдэг.*
3. *Дотоод уулзалт, сургалт, зааварчилгаагаар эрсдэлийн талаар мэдээлэл өгдөг.*
4. *Ёс зүй, авлигын эрсдэл зэрэг асуудлаар долоо хоног бүр 10 минутын мэдээлэл хийдэг.*
5. *Хууль бус амлалт өгөх, гадны нөлөөнд автах, хувийн ашиг сонирхол гаргах, байгууллагын болон албаны нууц задруулах гэх мэт асуудлууд гаргахгүй байхыг нийт албан хаагчдад мэдээлдэг.*

Тус байгууллагад эрсдэлийн түвшинд дараах нөхцөл байдлын тодорхойлсон байна.

1. *Боловсон хүчин хүний нөөцийн дутагдал*
2. *АЗ гэрчилгээтэй төлөөлөл нь үнэлгээний хороонд ажиллах хүсэл сонирхол бага, хуралд идэвхгүй, оролцдоггүй*
3. *Оновчгүй, уялдаагүй төлөвлөлтийн улмаас худалдан авах ажиллагаа үр дүнгүй, амжилтгүй болох*
4. *Төсөл, арга хэмжээний зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар зэрэг шаардлагатай материалыг захиалагч байгууллагуудаас цаг хугацаандаа ирүүлдээгүй нь худалдан авах ажиллагаа амжилтгүй болж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв татагдах*
5. *Мэдээлэл, файл нөөцлөлт (backup) хангалтгүй, өгөгдөл устах эрсдэл*
6. *[www.Tender.gov.mn](http://www.Tender.gov.mn) системийн доголдол, гацалт их байдаг*
7. *Тендерийн материалын цахим архивын баримтыг хадгалах сервер, тоног төхөөрөмж дутмаг*

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлон, мэдээлэх, сануулах үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж байгаа хэдий ч эрсдэлийг удирдах тусгайлсан бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийг удирдах ажлын хэсэг томилоогүй, баримт бичгээр баталгаажуулаагүй, эрсдэлийг тохиолдох магадлал, үр нөлөөгөөр нь үнэлээгүй тул тус байгууллагын эрсдэлийн удирдлагыг **1 дүгээр түвшинд буюу ЭХЛЭЛИЙН** түвшинд байна гэж дүгнэлээ.

### **3.3. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР**

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Монгол улсын Засгийн газрын 2011 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн байгууллагын даргын 2024.03.15-ны өдрийн тушаалаар “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг өөрийн үйл ажиллагааны чиг үүрэгт нийцүүлэн боловсруулж, батлан хэрэгжүүлж байна. Бие даасан орон тоонд Дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн ажилладаг нь дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулах давуу тал болж байна.

Тайланд онд дараах 5 чиглэлд 24 арга хэмжээг төлөвлөн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан баталсан байна.

Үүнд:

#### **1. Санхүү, төсвийн хэрэгжилт:**

1. 2026 оны төсвийн төлөвлөлт, 2025 оны төсвийн бүрдүүлэлт, хуваарилалт зарцуулалтад хяналт тавих, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах
2. Ажилд томилогдох, чөлөөлөгдөх албан хаагчдад төрийн болон албаны нууцтай танилцах, сахин мөрдөхөд чиглэсэн эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, нууцын баталгааг бичгээр гаргуулан авах ажилд хяналт хэрэгжүүлэх
3. Санхүү төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
4. Өмч хөрөнгийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх

#### **2. “Худалдан авах ажиллагааны ил тод байдал:**

1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулах, хэрэгжилтийг хангах
2. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны дүгнэлт, зөвлөмжид хяналт тавих
3. Тендерт шалгарсан оролцогч нарын тендерт санал болгосон ажиллах хүчээ ажлын явцад ажиллуулж байгаа эсэхэд хяналт тавих
4. Тендерт шалгарсан компанийн гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавих
5. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хяналт шинжилгээ хийх асуудлаар худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх

#### **3. Цахим системийн ашиглалт:**

1. Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтад хяналт тавьж, худалдан авах ажиллагааны ил тод байдалд мониторинг хийх
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөх
3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих
4. Тендер шалгаруулалтын баримт бичгийг хууль, журам, жишиг баримт бичгийн дагуу боловсруулагдсан эсэхэд хяналт шалгалт хийх
5. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажиллагаанд хяналт тавих

#### 4. Худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

1. Харьяа байгууллагуудын Худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих
2. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт гаргах, тайлагнах

#### 5. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хяналт, шалгалт

1. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх
3. Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
4. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх
5. Ажилтны гүйцэтгэх ажлын чиг үүрэгтэй хамаарал бүхий мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх давтан сургалт, мэргэшүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд (Сургалтын төлөвлөгөө, нийгмийн баталгааны хөтөлбөр, ажилчдын ажиллах нөхцөл) хяналт тавих
6. Байгууллагын 2026 оны Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх
7. Байгууллагын нээлттэй мэдээллийг үнэн, зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд тайлагнасан байдалд хяналт шалгалт хийх

2026 оны 1-р улирлын байдлаар дараах 2 удаагийн хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан батлуулж, хяналт шалгалт үргэлжилж байна.

1. 2026 оны худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын баримт бичигт хяналт, шалгалт хийх ажлын удирдамж
2. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын удирдамж

Дээрх 2 дотоод хяналт шалгалтын удирдамжийн хугацаа дуусгавар болоогүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын төлөвшил 3 дугаар түвшинд буюу ТОМЬЁОЛСОН түвшинд байна гэж дүгнэлээ.

#### ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025.12.04-ний өдрийн 02/58 дугаар тогтоолоор аймгийн 2026 оны төсвийг баталжээ.

Тус тогтоолын 2 дугаар хавсралтаар Аймгийн төсвөөс 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 332,574,910.6 мянган төгрөг, 2026 онд санхүүжих дүнг 224,391,775.4 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

*Орхон аймаг. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ /мян.төг/*

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №02/58 дугаар тогтоол	
		Ажлын тоо	Төсөвт өртөг
1	<b>Шилжих хөрөнгө оруулалт</b>		<b>91,207,952.3</b>
1.1	Барилга байгууламж	180	87,255,054.1
1.2	Тоног төхөөрөмж	4	724,429.0
1.3	Зөвлөх үйлчилгээ		3,228,469.2
2	<b>Шинээр эхлэх хөрөнгө оруулалт</b>		<b>222,388,330.3</b>

2.1	Барилга байгууламж	42	156,859,594.9
2.2	Их засвар	67	43,549,764.8
2.3	Тоног төхөөрөмж	47	12,849,970.5
2.4	Зөвлөх үйлчилгээ	1	3,050,000.0
2.5	Цахим систем	3	6,079,000.0
2.6	Төсөл, хөтөлбөр	162	18,978,628.0
<b>Нийт</b>			<b>332,574,910.6</b>

Эх үүсвэр. Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024/12/31 ны № 17 тогтоол, III-р хавсралт,

## БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЦАХИМ СИСТЕМД ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД НИЙТЭЛЭСЭН ЭСЭХ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт зааснаар өөрийн харьяа байгууллагын (Орхон аймгийн Засаг дарга) худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан нэгтгэж, нийт 232,645,215.7 мянган төгрөгийн 178 арга хэмжээг цахим системд оруулж, МАЯГТ-4 ийн дагуу бэлтгэн 2026.01.16-ны өдөр гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.

1. Орхон аймгийн Засаг дарга- 178 төсөл, арга хэмжээ – 232,645,215.7 мян.төг
2. Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар – 129 төсөл арга хэмжээ - 12,246,472.4 мян.төг
3. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар – 54 төсөл арга хэмжээ - 45,614,949.5 мян.төг
4. Хот тохижуулах газар – 12 төсөл арга хэмжээ - 45,614,949.5 мян.төг
5. Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар -1 төсөл арга хэмжээ - 60,800.0 мян.төг

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ХАА-ны төрөл	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №02/58 дугаар тогтоол			
			Ажлын тоо	Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Тендер шалгаруулалтын арга
<b>1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт</b>						
1	Барилга, байгууламж шинээр барих	ажил	10	36,819,185.3	19,390,133.8	НТШ-10
2	Инженерийн шугам сүлжээ	ажил	5	3,853,958.2	3,813,588.2	НТШ-4 ХА-1
3	Гэрэлтүүлэг цахилгааны ажил	ажил	9	14,757,684.5	14,757,684.5	НТШ-7 ХА-2
4	Автозамын засвар, зогсоол, буудал	ажил	32	112,839,583.2	53,890,317.6	НТШ-29 ХА-3
5	Камержуулалт, шилэн кабель татах	ажил	2	857,940.6	857,940.6	НТШ-2
6	Гэрлэн дохио	ажил	1	106,579.3	106,579.3	ХА-1
7	Амралт, чөлөөт цагийн талбай, орчны тохижилт	ажил	30	17,068,917.9	17,068,917.9	НТШ-30
8	Барилгын засвар, бусад	ажил	19	10,454,075.5	10,454,075.5	НТШ-12 ХА-7
	<b>ОНТХО-ын нийт дүн /ажил/</b>		<b>108</b>	<b>196,757,924.7</b>	<b>120,339,237.7</b>	
1	Бараа, тоног төхөөрөмж худалдан авах	бараа	49	18,868,970.5	18,868,970.5	НТШ-20 ХА-11 ШХА-14 НЭҮХА-3 ЕГА-1

	<b>ОНТХО-ын нийт дүн /бараа/</b>		<b>49</b>	<b>18,868,970.5</b>	<b>18,868,970.5</b>	
1	Үйлчилгээ худалдан авах	үйлчилгээ	2	3,110,000.0	3,110,000.0	НТШ-1 ХА-1
	<b>ОНТХО-ын нийт дүн /үйлчилгээ/</b>		<b>2</b>	<b>3,110,000.0</b>	<b>3,110,000.0</b>	<b>НТШ-1 ХА-1</b>
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн		159	218,736,895.3	142,318,208.2	
<b>2.Авто замын сангийн хөрөнгө оруулалт</b>						
1	Авто замын засвар	ажил	1	2,752,191.3	2,752,191.3	НТШ-1
	АЗЗ-ын нийт дүн		1	2,752,191.3	2,752,191.3	
<b>3.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт</b>						
1	Авто замын засвар	ажил	1	1,106,736.7	1,106,736.7	НТШ
2	Камержуулалт хийх	ажил	1	100,000.0	100,000.0	ХА
3	Барилгын засвар, бусад	ажил	5	436,843.4	436,843.4	НТШ-1 ХА-4
	<b>нийт</b>		<b>7</b>	<b>1,643,580.1</b>	<b>1,643,580.1</b>	
1	Бараа, тоног төхөөрөмж худалдан авах	бараа	4	187,000.0	187,000.0	НТШ-1 ХА-2 ШХА-1
	<b>Нийт барааны дүн</b>		<b>4</b>	<b>187,000.0</b>	<b>187,000.0</b>	
	Үйлчилгээ	Үйлчилгээ	3	801,000.0	801,000.0	НТШ-3
	<b>Нийт</b>		<b>3</b>	<b>801,000.0</b>	<b>801,000.0</b>	
	Байгаль хамгаалах сангийн нийт хөрөнгө оруулалтын дүн		14	2,631,580.1	2,631,580.1	
	<b>Аймгийн хөрөнгө оруулалтын нийт дүн</b>		<b>174</b>	<b>224,120,666.7</b>	<b>147,701,979.6</b>	

### **УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДЭЖ БУЙ ЭРХ ШИЛЖСЭН АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

2026 онд Боловсролын сайдын багцаас 3 ажил, Эрчим хүчний сайдын багцаас 1 ажил нийт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 4 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах эрхийг Орхон аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

2026 оны эхний 4 сарын байдлаар Орхон аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт нийт 19,496,300.0 мянган төгрөгийн 4 удаагийн хөрөнгө оруулалтын ажлыг эрх шилжүүлэн, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Үүнд:

1. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Рашаант багт 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилга ажил
2. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил багт 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилга барих ажил
3. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянбулагт багт Спорт заалны барилга барих ажил
4. БАГЦ-22-Орхон аймгийн Баян-Өндөр сумын Булагт багт баригдах 35/10 кВ-ын 2х20 МВа дэд станц БУА ЭХЯ/20260101026 барих ажил

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДЭЖ БУЙ ЭРХ ШИЛЖСЭН АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА**

№	ТЭЗ байгууллага	Төсөл/ажил	Багцын нэр	Худалдан авах арга	Нийт төсөвт өртөг (мян.төг)	Төндөр зарласан огноо	Оролцогчдын Тоо	Шалгарсан компани	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн	Дотоод аудит хийсэн эсэх	Илэрсэн зөрчил	Авсан арга хэмжээ
Улсын төсвийн хөрөнгө оруулалт /Орхон аймагт эрх шилжиж ирсэн/													
1	Орхон аймгийн Засаг дарга	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/		НТШ	6,075,000.0	2026.02.09	2	Сэнгүн констракшн ХХК	гэрээ байгуулах шатанд явж байна.	5,551,900.0	Үгүй	байхгүй	
2	Орхон аймгийн Засаг дарга	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/		НТШ	5,757,100.0	2026.02.09 2026.03.30	3	Засагт ханы оргил ХХК	гэрээ байгуулах шатанд явж байна.	4,969,000.0	Үгүй	байхгүй	
3	Орхон аймгийн Засаг дарга	Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/		НТШ	1,499,700.0	2026.02.10	1	Эрхэт бүтээл констракшн ХХК	гэрээ байгуулах шатанд явж байна.	864,270.0	Үгүй	байхгүй	
4	Орхон аймгийн Засаг дарга	БАГЦ-22 Булагт багт баригдах 35/10 кВ-ын 2х20 МВа дэд станцын БУА /Орхон аймаг, Баян-Өндөр сум		НТШ	6,164,500.0	2026.03.03	5	Меса инженеринг ХХК	гэрээ байгуулах шатанд явж байна.	5,856,275.0	Үгүй	байхгүй	
		Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн			19,496,300.0		11			17,241,445.0			

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.” хэсэг, тус хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 “үнэлгээний хороо байгуулах” заалт, 50 дугаар зүйл “Үнэлгээний хороо” заалт, 50.1.2 “ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй.” заалт, 50.3 дахь “Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна.” хэсэг, 50.5 “Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.” зэрэг хэсгүүдийг үндэслэн улсын төсвөөс эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах “Үнэлгээний хороо”-г Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан байна.

№	ХО-ын нэр	Байршил	Эхлэх хугацаа Дуусах хугацаа	Үнэлгээний хороо байгуулсан захирамжийн дугаар	Эрх шилжүүлсэн шийдвэр	Нийт төсөвт өртөг /сая.төг/	2026 онд санхүүжих дүн /сая.төг/	2026 онд Орон нутгийн төсвөөс санхүүжих дүн /сая.төг/	2027 онд санхүүжих дүн /сая.төг/	Түншлэлийн гэрээ байгуулсан эсэх	Тендер зарласан, нээсэн огноо
1	Сургуулийн барилга: 250 суудал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Рашаант баг			Монгол улсын Боловсролын сайдын 2026.01.01-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэх тухай” А/02 дугаар тушаалын 4-р хавсралтаар баталсан жагсаалтын №18, 19, 20	6,075.0	2,407.5	2,035.6	1,279.7		
2	Сургуулийн барилга: 250 суудал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Говил баг	2020 - 2025	2026 02.04 А/111  2026 03.03 А/179		5,003.8	1,857.8		3,146.0		2026 02.10 - 2026 03.09
3	Спорт заалны барилга	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг				1,499.7	979.0				

4	БАГЦ-22 Булагт багт баригдах 35/10 кВ-ын 2х20 МВа дэд станцын БУА /Орхон аймаг, Баян-Өндөр сум, ЭХЯ/20260101026	Орхон аймаг, Баян-Өндөр сум		2026 03.03 А/179	Монгол улсын Эрчим хүчний сайдын 2026.02.05- ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/30 дугаар тушаалаар 2026 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралт, Эрчим хүчний сайдын багцад батлагдсан УТ2603000291 кодтой “Бүс нутгийн найдвартай цахилгаан, дулаан хангамж, 2-р үе шат (Улсын хэмжээнд)” ТАХ-ний хүрээнд хэрэгжих	6,164.5	5,000.0				2026 03.03 - 2026 03.25

Сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар” болон тус зааврын батлагдсан маягтуудын дагуу тэмдэглэл хөтөлсөн байна.

#### 4. АУДИТЫН ҮР ДҮН

**1. “ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН РАШААНТ БАГТ БАРИГДАЖ БУЙ “250 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА” БАРИХ АЖИЛ:**

Тус хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулалтад Сэнгүн констракшн ХХК, Жам ХХК-иуд материалаа ирүүлж, 2 оролцогч оролцсон байна. Сонгон шалгаруулалтаар Сэнгүн констракшн ХХК шалгарч, аймгийн Засаг даргын 2026.03.20-ны өдрийн 01/957 дугаартай албан бичгээр гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлж, 2026.04.15-ны өдрийн 01/1353 дугаартай гэрээ байгуулж, хяналт тавих тухай албан бичгийг Хотын захирагчийн албанд хүргүүлсэн байна. Барилгын тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих ажил гүйцэтгэхтэй холбоотой захиалагч, гүйцэтгэгч хамтран ажиллахаар түншлэлийн гэрээг “Жам” ХХК, “Морин сувд констракшн” ХХК-тай байгуулсан байна.

**2. ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ГОВИЛ БАГТ БАРИГДАЖ БУЙ “250 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА” БАРИХ АЖИЛ:**

Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэчийн сонгон шалгаруулалтад Цомбон тоосго ХХК (5,748.4 сая төгрөгийн үнийн санал өгч, 25.0 сая төгрөгийн баталгаа гаргасан), Засагт ханы оргил ХХК (4,858,0 сая төгрөгийн үнийн санал ирүүлж, 25.0 сая төгрөгийн баталгаа гаргасан) - иуд материалаа ирүүлж, 2 оролцогч оролцсон байна.

Тендерийн үнэлгээний хорооны 2026.03.20-ны өдрийн №03 дугаар хурлаар дээрх 2 компанийн тендерийн баримт бичгийн бүрдэл дутуу байсан тул гишүүд татгалзаж, 2024.03.30-2026.04.21-ний өдөр тус тендерийг дахин зарласан байна. Тендерийн нээлтийг 2026.04.21-ний өдөр нээхэд 1 оролцогч буюу Засагт ханы оргил ХХК дангаараа материал ирүүлж оролцсон байна. Тус оролцогч нь хуулийн шаардлагад нийцүүлэн Моденс ХХК-тай 2026.04.17-ний өдөр гэрээний төсөвт өртгийн 75% Засагт ханы оргил ХХК, 25%-ийг Моденс ХХК хариуцахаар түншлэлийн гэрээ байгуулсан байна.

Сонгон шалгаруулалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул аймгийн Засаг даргын 2026.04.24-ний өдрийн 02а/1606 дугаартай албан бичгээр Засагт ханы оргил ХХК (4,969.0 сая төгрөг)-тай хуанлийн 120 хоногийн хугацаатай гэрээ байгуулах эрх олгож, мөн 2026.05.13-ны өдрийн 01/1980 дугаартай “гэрээ байгуулж, хяналт тавих тухай” албан бичгийг Хотын захирагчийн албанд хүргүүлсэн байна.

Аудитын явцад Хотын захирагчийн албанаас дараах баримт материалыг татан авч хяналт хийж ажиллалаа.

Тус хөрөнгө оруулалтын барилгын угсралтын ажлын зураг болон төсөвт өртгийг анх 2020.03.23-ны өдөр Гранд тех ХХК 3,943.6 сая төгрөгөөр баталсан байна.

**3. ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН БАЯНБУЛАГ БАГИЙН “СПОРТ ЗААЛ”-НЫ БАРИЛГА БАРИХ АЖИЛ**

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянбулаг багийн нутаг дэвсгэрт баригдаж буй, “16 дугаар сургуулийн спорт заалны барилга” -ын ажлын зураг төсөл нь 2014.11.13-ны өдрийн №1559/2014 дугаартай Хот байгуулалт, орон сууцжуулалтын

яамны 2024.09.19-ний өдрийн №1754/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр албажсан байна.

Боловсролын Шинжлэх ухааны сайдын 2023.12.05-ны өдрийн А/542 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2024.03.11-ний өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлын шийдвэр, хийгдээгүй ажлын тоо, хэмжээ тодорхойлсон актыг үндэслэн хийгдээгүй ажлын төсвийг тооцож, Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас 2023.06.13-ны өдрийн №2/2713 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох хууль эрх зүйн актуудын заалтыг үндэслэн гэрээ цуцлагдсан, хийгдээгүй ажлын төсөвт магадлал хийх ажлыг зохион байгуулсан байна.

2026.04.08-ны өдөр захиалагч талыг төлөөлж Орхон аймгийн Засаг дарга, гүйцэтгэгч талыг төлөөлж, Эрхэт бүтээл констракшн ХХК-тай ХЗА-36/26 тоот гэрээг байгуулсан байна.

#### **4. БАГЦ-22- ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН БУЛАГТ 35/10 КВ-ЫН 2Х20 МВА ДЭД СТАНЦ” БАРИХ АЖИЛ:**

Тендер сонгон шалгаруулалтыг 2026.03.03-2026.03.25-ны өдөр зарласан байна. Тендерийн нээлтэд дараах 5 оролцогч оролцсон:

1. Эм Жи Эл Энержи ХХК (5,771.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 30.8 сая төгрөгийн баталгаа ирүүлсэн)
2. Цацрах цог ХХК (6,039.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 30.8 сая төгрөгийн баталгаа ирүүлсэн)
3. Эрчим хайрхан ХХК (5,786.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 30.8 сая төгрөгийн баталгаа ирүүлсэн)
4. Ганбүрд ХХК (5,804.8 сая т төгрөгийн төсөвт өртөгтэй, 30.8 сая төгрөгийн баталгаа ирүүлсэн)
5. Меса инженеринг (5,856.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 30.8 сая төгрөгийн баталгаа ирүүлсэн)

Тендерийн үнэлгээний хорооны 2026.04.21-ны өдрийн №03 дугаар хурлаар дээрх ажилд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул аймгийн Засаг даргын 2026.04.01-ний өдрийн 01/1240 дугаартай албан бичгээр Меса инженеринг ХХК (5,856.3 сая төгрөг)-тай хуанлийн 90 хоногийн хугацаатай гэрээ байгуулах эрх олгож, мөн 2026.04.14-ны өдрийн 01/1340 дугаартай “гэрээ байгуулж, хяналт тавих тухай” албан бичгийг Хотын захирагчийн албанд хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга /Захиалагч/ Меса инженеринг ХХК-тай 2026.04.22-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг 2026.06.02-2026.09.06-ны өдрийг хүртэл 90 хоногийн хугацаатай гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан байна.

Тус тендерт шалгараагүй дараах 4 оролцогчид хуулийн хугацаанд хариу хүргүүлж ажилласан байна. Үүнд:

1. Эм Жи Эл ХХК, Эрчим хайрхан ХХК-д нь тендерийн баримт бичигт хүний нөөцийн баримт /НДШТөлөлт/-ын бүрдэл дутуу шалтгаанаар татгалзаж 2026.04.01-ний өдрийн 01/1241, 02/1242 дугаартай албан бичгүүдээр ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсэгт заасны дагуу шаардлага хангаагүй тул татгалзсан тухай мэдэгдэл хүргүүлсэн байна.
2. Цацрах цог ХХК, Ган бүрд ХХК-д нь тендерийн баримт бичгийн шаардлагад тусгасан тээврийн хэрэгслийн шаардлага хангагдаагүй зэрэг шалтгаануудаар 2026.04.01-ний өдрийн 01/1243, 02/1244 дугаартай албан бичгүүдээр ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28

дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсэгт заасны дагуу шаардлага хангаагүй тул татгалзсан тухай мэдэгдэл хүргүүлсэн байна.

Аудитын явцад Эрдэнэт Хотын захирагчийн албанаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн дээрх 4 ажлын зураг, төсвийг татаж авч хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

Дээрх улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон аймагт эрх шилжсэн 4 ажлын санхүүжилтийг Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг гэрээнд тусгасан байна.

№	ХО-ын нэр	Ажлын зураг төсөв батлагдсан огноо	Зураг төсөв гүйцэтгэсэн компанийн нэр	Нийцлийн аудитын дүгнэлт
1	Сургуулийн барилга: 250 суудал /Рашаант баг/	2018	Гранд тех ХХК	<p>2025 онд Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн,</p> <p>Захиалагчийн зүгээс төсөвт өртгийг БТХ-ийн 2024.10.16-ны өдрийн 1868/2024 дугаартай дүгнэлтээр баталгаажуулсан төсөвт өртгөөр буюу 5,722,835.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг ирүүлсэн боловч тус магадлалын ерөнхий дүгнэлтээр төсвийн задаргаанд санхүүжилт авсан, нэрээр ажлын тоо хэмжээг дахин тооцож олгосон санхүүжилтийг төсөвт оруулсан, санхүүжилт олгосон ажлыг үлдэгдэл ажлын тоо хэмжээнд давхцуулан тооцсон, барилга угсралтын ажлын чанаргүй гүйцэтгэлээс шалтгаалан “дахин хийгдэх ажил” нэрээр төсөвт ажлын тоо хэмжээг тооцсон байна.</p> <p>2025 оны Төсвийн тухай хуульд тусгасан төсөвт өртгийг 2,121,447.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх нь үндэслэлтэй гэж дүгнэсэн байна.</p> <p>Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны 2024.10.16-ны өдрийн №1868/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр тус ажлын үлдэгдэл ажлын төсвийг 5,722,835.3 мянган төгрөгөөр баталсан байна.</p>

2	Сургуулийн барилга: 250 суудал /Говил баг/	2020	Гранд тех ХХК	<p>2025 онд Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, тендерийн хэмнэлт үүсээгүй, магадлалын ерөнхий дүгнэлтийн төсвийн задаргаанд хийгдээгүй ажилд санхүүжилт авсан, нэрээр ажлын тоо хэмжээг дахин тооцож олгосон санхүүжилтийг төсөвт оруулсан, санхүүжилт олгосон ажлыг үлдэгдэл ажлын тоо хэмжээнд давхцуулан тооцсон, барилга угсралтын ажлын чанаргүй гүйцэтгэлээс шалтгаалан “дахин хийгдэх ажил” нэрээр төсөвт ажлын тоо хэмжээг тооцсон байна. 2025 оны Төсвийн тухай хуульд тусгасан төсөвт өртгийг 1,812,853.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх нь үндэслэлтэй гэж дүгнэсэн байна.</p> <p>Магадлалын ерөнхий дүгнэлтээр тус ажлын зураг төслийг 2020.03.30-ны өдрийн 431/2020 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт өгч, захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хамтарсан 2023.03.15-ны өдрийн хурлын шийдвэр, Боловсролын ерөнхий газрын даргын 2024.03.11-ний өдрийн А/58 дугаар тушаал, хийгдээгүй ажлын тоо хэмжээ тодорхойлсон акт, холбогдох хууль эрх зүйн актуудыг үндэслэн хийгдээгүй ажлын төсвийг тооцсон байна.</p>
3	Спорт заалны барилга			<p>Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянбулаг багийн нутаг дэвсгэрт баригдаж буй, “16 дугаар сургуулийн спорт заалны барилга” -ын ажлын зураг төсөл нь 2014.11.13-ны өдрийн №1559/2014 дугаартай Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны 2024.09.19-ний өдрийн №1754/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр албажсан байна.</p> <p>Боловсролын Шинжлэх ухааны сайдын 2023.12.05-ны өдрийн А/542 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2024.03.11-ний өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлын шийдвэр, хийгдээгүй ажлын тоо, хэмжээ тодорхойлсон актыг үндэслэн хийгдээгүй ажлын төсвийг тооцож, Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас 2023.06.13-ны өдрийн №2/2713 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох хууль эрх зүйн актуудын заалтыг үндэслэн гэрээ цуцлагдсан, хийгдээгүй</p>

				ажлын төсөвт магадлал хийх ажлыг зохион байгуулсан байна.
4	БАГЦ-22 Булагт багт баригдах 35/10 кВ-ын 2х20 МВа дэд станцын БУА /Орхон аймаг, Баян-Өндөр сум, ЭХЯ/ 20260101026	2023	Бодит чадал ХХК	Тус ажлын төсвийг 2024 онд 6,164,527.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Орхон аймагт 2026 оны байдлаар Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Монгол улсын 2026 оны Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад эрх шилжин хэрэгжүүлэх, 19,496,300.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжиж байна.

Төсвийн төлөвлөлтөд хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем ([www.tender.gon.mn](http://www.tender.gon.mn) цахим системд нэвтрэн холбогдох мэдээллийг иж бүрэн байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

### 3.2 Илэрсэн асуудал

<b>Илэрсэн Асуудал-1</b>	Дотоод аудитын ажлын баримтаар АБ1003 Эрсдэлийн удирдлагын талаар авах ерөнхий асуулгыг удирдлагаас авч ажилласан боловч байгууллагын эрсдэлтэй холбоотой баримт материал огт ирүүлээгүй, байгууллагын хэмжээнд эрсдэлийг баримтжуулдаггүй.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> Худалдан авах ажиллагааны газар нь үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлон, мэдээлэх, сануулах үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж байгаа хэдий ч эрсдэлийг удирдах тусгайлсан бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийг удирдах ажлын хэсэг томилоогүй, баримт бичгээр баталгаажуулаагүй, эрсдэлийг тохиолдох магадлал, үр нөлөөгөөр нь үнэлээгүй.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/</b>	
<ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны А/191 дүгээр тушаалаар байгуулагдсан "Эрсдэлийн удирдлагын нийтлэг журам, гарын авлага боловсруулах ажлын хэсэг"</li> <li>2. "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого",</li> <li>3. "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар",</li> <li>4. "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал"</li> <li>5. ISO 31000-2018 Эрсдэлийн менежментийн стандарт,</li> </ol>	

6. ISO 31010-2018 эрсдэлийн үнэлгээний аргачлал зэрэг холбогдох баримт бичгүүдийг судлан, өөрийн байгууллагын эрсдэлийг удирдах бодлого, журмыг боловсруулан баталж мөрдүүлэх
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> АБ1003 Эрсдэлийн удирдлагын талаар авах ерөнхий асуулгад нотлох баримтад тулгуурлан хариулт ирүүлээгүй, эрсдэлийн талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/</b> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагад засаглах удирдлагын түвшинд хараат бус байдал алдагдах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх</li> <li>2. Үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэл үүсэх</li> <li>3. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын үнэ цэн, өгөөж буурах эрсдэлтэй</li> <li>4. Байгууллагын болон улсын хэмжээний бодлогын баримт бичгийн хэрэгжилт үнэн зөв, бодитой хэрэгжихгүй байх эрсдэлтэй</li> </ol>
<b>Зөвлөмж:</b> <ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан "Эрсдэлийн удирдлагын нийтлэг журам, гарын авлага боловсруулах ажлын хэсэг", "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого", "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар", "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал" зэрэг баримт бичгүүдээс үйл ажиллагаандаа сонгон хэрэгжүүлж, өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн эрсдэлийг удирдах бодлого, Эрсдэлийн журмыг боловсруулан баталж, мөрдүүлэх</li> <li>2. Эрсдэл хариуцсан нэгж / албан тушаалтан, ажлын хэсгийн удирдлагын тушаалаар томилох</li> <li>3. Байгууллагын бүх түвшинд учирч болзошгүй эрсдэл, аюулыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, эрсдэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, үр нөлөөг үнэлэх</li> </ol>

<b>Илэрсэн Асуудал-2</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Аудитын явцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баян булаг багт баригдаж буй Спорт заалны ажлын зургийг эх хувиар ирүүлээгүй, файлаар ирүүлсэн.</li> <li>2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил, бараа, үйлчилгээний худалдан авах ажиллагааны баримт бичгүүдийг яаралтай, хадгаламжийн нэгж болгон цахим хэлбэрт шилжүүлэн хадгалж, архивлах</li> </ol>
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 4 хөрөнгө оруулалтын ажлын тендер сонгон шалгаруулалтын баримт бичгүүдийг авч баримтын иж бүрдэл болон худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын хүрээнд нийцүүлэн зохион байгуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж ажиллалаа.	

Аудитаар Хотын захирагчийн албанаас дээрх 4 хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, нийцлийн аудитын дүгнэл, магадлалын ерөнхий дүгнэлтийг авч ажиллахад Баянбулаг багт баригдаж буй Спорт заалны барилга барих ажлын зураг эх хувиар байхгүй байсан бөгөөд файлаар зургийг ирүүлсэн.

#### **Байх ёстой шаардлага /шалгуур/**

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг

5.3.6. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна;

5.3.7. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивд хадгалуулна;

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 9 дэх хэсэгт “ашиглалтад оруулах барилга байгууламжийн зураг, төсөл, баримт бичгийг архивт хүлээлгэн өгч, Барилгын тухай хуулийн 34.1.7-д заасан мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх ажлыг захиалагч хариуцна” заалт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 “захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана” заалт, 48.4.1 “санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр” заалт, 48.4.2 “нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл” заалт, 48.4.3 “захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт” заалт, 48.4.4 “захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг” заалт, 48.4.5 “оролцогчдын ирүүлсэн тендер” заалт, 48.4.6 “үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж” заалт, 48.4.7 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл” заалт, 48.4.8 “захиалагчийн шийдвэр” заалт, 48.4.9 “худалдан авах гэрээ” заалт, 48.4.10 “энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг” заалт, 48.4.11 “бусад баримт бичиг” заалт, 48.5 “Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална” зэрэг заалт

#### **Асуудлын үндсэн шалтгаан:**

Холбогдох шатны байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн ажлын ажлын зураг, төсвийг үндэслэн зарладаг. Гэвч Баянбулаг багийн Спорт заалны барилга барих ажлын худалдан авах ажиллагааг ямар эх баримт, ажлын зураг дээр үндэслэн хийснийг баримтаар нотлох боломжгүй байна.

Аудитын явцад Хотын захирагчийн албанаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй эрх шилжсэн 3 ажлын зургийн эх хувиар, 1 ажлын зургийг файлаар татан авч хяналт хийж ажилласан.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/**

1. Мэргэжлийн байгууллагуудаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил зогсоох, улсын комисс хүлээж авах нөхцөл бүрдэхгүй байх,
2. Тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын санхүүжилт олгогдохгүй байх зэрэг өндөр эрсдэлүүд үүснэ.

**Зөвлөмж:**

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааг тухайн ажлын зураг, төсвийг үндэслэн зохион байгуулах
2. Холбогдох байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллах
3. Албан хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлж, баримт бичгийн иж бүрдлийг бүх шатанд ханган ажиллах

**4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Монгол улсын Сангийн сайдын 2026.04.16-ны өдрийн 01/3386 дугаартай албан бичгийг үндэслэн Орхон аймгийн Засаг даргын 2026.04.27-ны өдрийн 31/26 дугаартай удирдамжийн хүрээнд нийцүүлэн Худалдан авах ажиллагааны газрын 2026.01.02-2026.04.30-ны өдрийн байдлаар Орхон аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн зарлагдсан худалдан авах ажиллагааны явцад дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Орхон аймгийн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025.12.04-ний өдрийн №02/58 дугаар тогтоол, 2026.01.16-ны өдрийн Маягт-4 өөр хүргүүлсэн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр энэ онд аймгийн хөрөнгө оруулалтаар нийт 232,645,215.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 178 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг баталснаас 2026 онд 140,264,608.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнээс 67.9% -ийг ажил, 30.8% -ийг бараа, 1.3% -ийг үйлчилгээ эзэлж байна.

Тус тогтоолоор батлагдсан 178 ТАХ-ний 70%-ийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 18.9% -ийг харьцуулалтын аргаар, 8.6% -ийг шууд худалдан авалтаар, 1.7% -ийг НЭҮХА-аар, 0.5% -ийг ерөнхий гэрээний аргаар зохион байгуулахаар баталсан байна.

Үндэсний аудитын газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтад аймаг, орон нутгуудад эрх шилжсэн хөрөнгө оруулалтуудын ажлын гүйцэтгэлд, Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн хэмжээний хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр аудит хийж, хяналт хэрэгжүүлж, дүгнэлт өгч ажилласан байна.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2026.04.30-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 4 ажлын гүйцэтгэл болон худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үйл явцыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулсан тул **ХАНГАЛТТАЙ** гэж дүгнэлээ.

Энэ удаагийн аудитын удирдамжийн хамрах хүрээний үйл явцад засаглал, эрсдэл, дотоод хяналтын тогтолцоог үнэлэх асуудлууд багтаагүй боловч Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын секторын дотоод аудитын аргачлал”, стандартын дагуу дотоод аудитыг гүйцэтгэн АБ 1001, АБ 1002, АБ 1003, АБ 1004 ажлын баримтаар байгууллагын удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдээс асуулга авч засаглал, эрсдэл, дотоод хяналтын тогтолцооны түвшинг үнэлэн, илэрсэн асуудалд тусган зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

	Төлөвшлийн үнэлгээ
<b>ЗАСАГЛАЛЫН УДИРДЛАГА</b>	Худалдан авах ажиллагааны газар нь Төрийн худалдан авах ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулж, засаглалын удирдлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлж ажиллаж байгаа хэдий ч үйл ажиллагааны баримтжуулалт хийгдээгүй тул засаглалын удирдлагыг <b>3 дугаар түвшинд буюу ТОМЬЁОЛСОН</b> түвшинд байна гэж дүгнэлээ.
<b>ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>	Тус байгууллага нь үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлон, мэдээлэх, сануулах үйл ажиллагааг байгууллагын шуурхай хуралдаанд нээлттэй сануулах хэлбэрээр удирдан хэрэгжүүлж байгаа нь эрсдэлийг зохистой удирдах үйл явц биш юм. Тус байгууллага нь худалдан авах ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг удирдах тусгайлсан бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийг удирдах ажлын хэсэг томилоогүй, баримт бичгээр баталгаажуулаагүй, эрсдэлийг тохиолдох магадлал, үр нөлөөгөөр нь үнэлээгүй, аудитын явцад эрсдэлтэй холбоотой баримт материал ирүүлээгүй тул тус байгууллагын эрсдэлийн удирдлагыг <b>1 дүгээр түвшинд буюу ЭХЛЭЛИЙН</b> түвшинд байна гэж дүгнэлээ.
<b>ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>	Монгол улсын Засгийн газрын 2011 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн байгууллагын даргын 2024.03.15-ны өдрийн тушаалаар “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг өөрийн үйл ажиллагааны чиг үүрэгт нийцүүлэн боловсруулж, батлан хэрэгжүүлж байна. Бие даасан орон тоонд Дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн ажилладаг нь дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулах давуу тал болж байна. Тайланд онд дараах 5 чиглэлд 24 арга хэмжээг төлөвлөн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөсөн хугацаандаа дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа тул Дотоод хяналтын тогтолцоог <b>3 дугаар түвшинд буюу ТОМЬЁОЛСОН</b> түвшинд байна гэж дүгнэлээ.

Цаашид аудитаар илэрсэн асуудалд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулан, эрсдэлийг удирдах бодлого, журмыг боловсруулан, учирч болзошгүй тодорхойлон үнэлж, бууруулах ажлыг төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллах, мөн аймгийн хэмжээнд Төрийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд, тогтоосон хугацаанд үр дүнтэй, хяналттай зохион байгуулж, биелэлтийн тайланг албан бичгээр **2026** оны **08** дугаар сарын **10**-ны өдрийн дотор ирүүлж ажиллахыг хүсье.

Улсын төсвийн 2026 оны орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжилтийн явц, үр дүнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитыг 2026.05.15-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэж, аудитын тайланг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын удирдлага, холбогдох албан хаагчдад танилцуулж, Сангийн яамны Санхүүгийн хяналт, дотоод аудит, үнэлгээний газарт албан бичгээр хүргүүлж ажиллалаа.

**ДОТООД АУДИТ ГҮЙЦЭТГЭСЭН:**


САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ДОТООД АУДИТОР  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ



Л.БУЛГАНЦЭЦЭГ

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**


САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА-САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.САЙЗМАА

**ТАНИЛЦСАН.**

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА



Б.ОЮУНБАЯР

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.ЭРДЭНЭСҮХ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТТӨР